



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЭРДЭНЭС ОЮУ ТОЛГОЙ ХХК-ИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/64/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Энхдалай
Утас: 261885 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn
Ахлах аудитор: М.Лхагвасүрэн
Утас: 261740 Цахим хаяг: lkhagvasuren@audit.gov.mn
Гэрээгээр гүйцэтгэсэн Нийслэл аудит ХХК-ийн
Захирал: Т.Сугарсүрэн
Утас: 70110095 Цахим хаяг: info@niislelaudit.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	7
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Материаллаг байдал.....	11
4. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
4.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	11
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	12
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	12
4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	14
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	15
5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	15
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
8. Аудитын илрүүлэлт.....	16
8.1 Залруулсан алдаа.....	16
8.2 Зөвлөмж.....	17
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААНОАТТХ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль
ЗГ	Засгийн газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УИХ	Улсын Их Хурал



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЭРДЭНЭС ОЮУ ТОЛГОЙ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Н.ЦЭРЭНБАТ ТАНАА

2022.03.15 № 07/608
танай _____-ны № _____-т

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс оюу толгой ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Эрдэнэс оюу толгой ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад гол үйл явдлыг санхүүгийн тайланд толилуулсан байна.

Бид компанийн хүлээж болзошгүй үүрэг хариуцлага, түүнтэй холбоотой асуудлаар дүгнэлтээ өөрчлөөгүй болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Байгууллага нь нийт орлогыг Оюу толгой төслийн бүтээн байгуулалтын шийдвэр тодорхойгүй байдлын улмаас төлөвлөөгүй бөгөөд нийт зардлыг 2,118.0 сая төгрөгөөр тогтоож, үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 129.2 сая төгрөгийг төсөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 5,698.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 4,584.0 сая төгрөгийн

зардал гарган 1,114.8 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6.1 дэх хэсэгт заасны дагуу 2021 оны үйл ажиллагаанд шаардлагатай бараа, ажил, үйлчилгээний 1 худалдан авах ажиллагаанд 129.2 сая төгрөг төлөвлөснөөс 27 нэр төрлийн бараа ажил үйлчилгээнд 85.3 сая төгрөг зарцуулсан байна.

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээлэлд үүрэг хариуцлага хүлээдэг. Байгууллагын жилийн тайланд 3 зорилтын хүрээнд 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	45,427,194.45	5,348,962,236.92
1.1.2	Дансны авлага	6,347,725.40	
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага		13,882,461.09
1.1.4	Бусад авлага		16,036,363.65
1.1.6	Бараа материал		62,706,900.00
1.1.7.1	Урьдчилж төлсөн зардал		
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	51,774,919.85	5,441,587,961.66
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	67,684,161.00	109,086,714.69
1.2.2	Биет бус хөрөнгө	253,694.00	11,103,694.00
1.2.9	Урт хугацаат хөрөнгө оруулалт	2,689,647,010,000.00	2,747,782,420,000.00
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	101,336,195.08
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,689,714,947,855.00	2,748,003,946,603.77
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,689,766,722,774.85	2,753,445,534,565.43
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг		1,076,427,369.00
2.1.1.3	Татварын өр	2,765,533.35	596,194,953.01
2.1.1.4	НДШ-ийн өглөг		4,673,769.72
2.1.1.6	Хүүгийн өглөг	3,500,933,021.51	4,552,001,905.36
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	3,503,698,654.86	6,229,297,997.09
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	7,573,679,430.00	9,104,329,430.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	7,573,679,430.00	9,104,329,430.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	11,077,378,084.86	15,333,627,427.09
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч-төрийн	300,000,000.00	300,000,000.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	2,689,647,010,000.00	2,747,782,420,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(11,257,665,310.01)	(9,970,512,861.66)
2.3.11	Эздийн өмчийн дүн	2,678,689,344,689.99	2,738,111,907,138.34
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,689,766,722,774.85	2,753,445,534,565.43

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

			/төгрөгөөр/
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	-	
2	Борлуулалтын өртөг	-	
3	Нийт ашиг (алдагдал)	-	
5	Хүүгийн орлого	7,085.59	
8	Бусад орлого		5,698,825,000.00
10	Ерөнхий удирдлагын зардал	868,464,374.76	3,378,412,659.16
11	Санхүүгийн зардал	861,887,006.13	900,000,000.00
12	Бусад зардал		163,575,280.12
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	38,845.60	(200.42)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(1,730,305,449.69)	1,256,836,860.30
19	Орлогын татварын зардал	708.56	142,041,214.04
	Хойшлогдсон татварын зардал (орлого)		71,020,607.02
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(1,730,306,158.25)	1,114,795,646.26
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(1,730,306,158.25)	1,114,795,646.26
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
24	Орлогын нийт дүн	(1,730,306,158.25)	1,114,795,646.26
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

					/төгрөгөөр/
Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн	
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	300,000,000.00	2,304,003,540,000.00	(9,512,541,259.43)	2,294,790,998,740.57	
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(14,817,892.32)	(14,817,892.32)	
Залруулсан үлдэгдэл	300,000,000.00	2,304,003,540,000.00	(9,527,359,151.75)	2,294,776,180,848.25	
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(1,730,306,158.25)	(1,730,306,158.25)	
Өмчид гарсан өөрчлөлт		385,643,470,000.00		385,643,470,000.00	
Зарласан ногдол ашиг					
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	300,000,000.00	2,689,647,010,000.00	(11,257,665,310.01)	2,678,689,344,689.99	
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			172,356,802.10	172,356,802.10	
Залруулсан үлдэгдэл	300,000,000.00	2,689,647,010,000.00	(11,085,308,507.92)	2,678,861,701,492.09	
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			1,114,795,646.26	1,114,795,646.26	
Өмчид гарсан өөрчлөлт		58,135,410,000.00		58,135,410,000.00	
Зарласан ногдол ашиг					
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	300,000,000.00	2,747,782,420,000.00	(9,970,512,861.66)	2,738,111,907,138.34	

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Бусад мөнгөн орлого		5,698,825,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн	867,135,696.02	1,809,156,023.47
	Ажиллагчдад төлсөн	417,175,798.14	735,813,073.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	113,000,000.00	235,000,000.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	26,909,627.00	29,555,065.00
	Ашиглалтын зардалд төлсөн	632,600.00	
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	8,994,864.00	11,965,597.00
	Хүүгийн төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	68,483,994.12	75,480,315.55
	Даатгалын төлбөрт төлсөн		
	Бусад мөнгөн зарлага	231,938,812.76	721,341,972.92
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(867,135,696.02)	3,889,668,976.53
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	7,794.15	3,828,840.00
	Хүлээн авсан хүүгийн орлого	7,794.15	
	Хүлээн авсан ногдол ашиг		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		3,826,840.00
2.2	Мөнгөн зарлагын дүн	14,148,790.00	120,612,573.64
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	14,148,790.00	85,356,610.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		11,000,000.00
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		24,255,963.64
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(14,140,995.85)	(116,783,733.64)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	892,625,000.00	
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	892,625,000.00	1,530,650,000.00
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн		
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	892,625,000.00	1,530,650,000.00
4	Валютин ханшийн зөрүү	38,845.60	(200.42)
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	11,387,153.73	5,303,535,042.47
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	34,040,040.72	45,427,194.45
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	45,427,194.45	5,348,962,236.92

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Орлогын төрөл						
1	Санхүүжилт	892,625,000.00	-		--	
2	Бусад орлого	-	-	5,698,825,000.00	5,698,825,000.00	-
Цалин нийгмийн хамгааллын зардал		564,854,570.16	1,334,737,560.00	1,068,208,278.47	267,069,281.53	80.0
1	Цалин хөлс шагнал	1,054,200,000.00	852,998,874.78	201,201,125.22	80.9	80.9
2	Нэмэгдэл цалин	122,256,000.00	76,100,000.00	46,156,000.00	62.2	62.2
3	Нийгмийн даатгалын шимтгэл	158,281,560.00	139,109,403.69	19,712,156.31	87.9	87.6
Урсгал зардлын төсөв		276,597,266.20	653,580,000.00	2,344,967,719.58	(1,691,387,719.58)	358.8
1	Бичиг хэргийн зардал	8,000,000.00	10,000,000.00	9,985,000.00	15,000.00	99.9
2	Веб сайт интернэтийн зардал	8,128,000.00	9,000,000.00	8,923,000.00	77,000.00	99.1
3	Шуудан холбооны зардал	1,977,242.98	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.0
4	Машин үйлчилгээ сэлбэг	5,267,530.00	11,000,000.00	8,195,330.00	2,804,670.00	74.5
5	Гэрээт ажлын зардал	93,728,219.00	90,000,000.00	90,000,000.00	0.00	100.0
6	Санхүүгийн тайлан баталгаажуулах зардал	9,900,000.00	15,000,000.00	9,900,000.00	5,100,000.00	66.0
7	Гадаад, дотоод сургалт, зар сурталчилгааны зардал	34,625,600.00	40,000,000.00	26,099,000.00	13,901,000.00	65.2
8	Шатахууны зардал	8,394,864.00	15,000,000.00	11,949,724.27	3,050,275.73	79.7
9	Байрны урсгал зардал	632,600.00	2,000,000.00	-	2,000,000.00	-
10	Зочид төлөөлөгчийн зардал	9,224,313.36	8,480,000.00	1,242,800.00	7,237,200.00	14.7
11	Ном, хэвлэл захиалгын зардал	4,081,350.00	2,100,000.00	2,100,000.00	0.00	100.0
12	Гадаад томилолтын зардал	4,696,500.00	10,000,000.00		10,000,000.00	-
13	Дотоод томилолтын зардал	-	10,000,000.00	9,123,978.00	876,022.00	91.2
14	Түрээсийн зардал	43,346,647.00	281,000,000.00	136,764,822.27	144,235,17.73	48.7
15	Ажилтнуудын нийгмийн асуудал, арга хэмжээ	31,375,645.86	50,000,000.00	24,698,341.27	25,301,658.73	49.4
16	Хууль зүйн мэргэжлийн туслалцааны зардал	4,479,250.00			0.00	-
17	Хангамжийн материалын зардал	6,333,407.00	13,000,000.00	13,000,000.00	0.00	100.0
18	Даатгал ба эрсдэлийн зардал	2,406,097.00	2,000,000.00	315,000.00	1,685,000.00	15.8
19	Зөвлөх үйлчилгээ, судалгааны зардал	-	80,000,000.00	1,987,670,723.77	(1,907,670,723.77)	2484.6
Нийт зардлын дүн		841,451,836.36	1,988,317,560.00	3,413,175,998.05	(1,424,858,438.05)	171.7
Шаардлагатай хөрөнгө оруулалт		14,148,790.00	129,150,000.00	85,356,610.00	43,793,390.00	66.1
1	Компьютер, дагалдах хэрэгсэл	89,800,000.00	85,356,610.00	4,443,390.00	95.1	95.1
2	Тавилга, эд хогшил	19,350,000.00		19,350,000.00	-	-
3	Тээврийн хэрэгсэл	-		-	-	-
4	Архивын программ хангамж, сервер, шаардлагатай тоног төхөөрөмж	20,000,000.00		20,000,000.00	-	-
Нийт дүн		855,600,626.36	2,118,007,560.00	3,498,532,608.05	1,380,525,048.05	165.2

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Эрдэнэс оюу толгой ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бөхөн аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад хууль, тогтоомж, дүрэм, журмыг хэрэгжүүлэх, нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн программ хангамжийг шинэчлэхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 2 дугаар сарын 15-наас 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Нийслэл аудит ХХК-ийн ахлах аудитор Л.Ганзориг, аудитор Д.Ариунбулган нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Л.Сарантуяа, захирал Т.Сугарсүрэн нар тус тус хэрэгжүүлсэн.

Эрдэнэс оюу толгой ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 01/35 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн. Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлд Компанийн хяналтын тогтолцоог Хувьцаа эзэмшигчийн хяналт, Дотоод хяналт, Хөндлөнгийн хяналт гэсэн 3 чиглэлээр хэрэгжүүлнэ, мөн дүрмийн Гүйцэтгэх захирлын үүрэг 6.7.5-д хянан шалгагчийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, зөвшилцсөний дагуу томилно гэж заасан ч дотоод хяналтыг хэрэгжүүлэгч этгээдийг тодорхой зааж өгөөгүй. Түүнчлэн толгой компанийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооноос 2020, 2021 оны компанийн санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт хийгдээгүй байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирохгүй байна. Компани нь өөрийн толгой компани болох Эрдэнэс Монгол ХХК-ийн бодлогын баримт бичгийг баримтлан ажиллаж байгаа бөгөөд стандарт, хууль дүрэм журмын өөрчлөлтийн нөлөөнөөс шалтгаалж өөрийн үйл ажиллагаандаа тохирсон тусгай бодлого, горимыг боловсруулан ажиллах шаардлагатай байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Эрдэнэс оюу толгой ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 1,730.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 25.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Эрдэнэс оюу толгой ХХК-ийн зорилго нь Компанийн дүрмийн 3.1-д "Монгол Улс, ард иргэдийнхээ эрх ашгийг тэргүүн ээлжид тавьж, төслийн өгөөжийг дээшлүүлэн, төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрх үүргийг хэрэгжүүлэх, удирдах эрхийг хэрэгжүүлэх" явдал юм.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг Компанийн дүрмийн 3.3-т "Оюу Толгой ХХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмших эрхийг хэрэгжүүлэх, Хувьцаа эзэмшигчийн хувьд Оюу Толгой ХХК-ийн үйл ажиллагаанд оролцох, Оюу Толгойн ашигт малтмалын ордыг ашиглах үеийн төрийн оролцоог хэрэгжүүлэх, төрд ногдох ашгийг төвлөрүүлэх" гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг компанийн үүсгэн байгуулагч бөгөөд төрийн мэдлийн хувьцааг эзэмшигч "Эрдэнэс Монгол" ХХК байна.

Тайлант онд компанийн үйл ажиллагаанд дараах онцлог үйл явдлууд тохиолдсон байна. Үүнд:

- Оюу толгой төслийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 274 тоот тогтоолын 5-д заасны дагуу Эрдэнэс оюу толгой ХХК-ийн зүгээс төсөлд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэх ажлыг санхүүжүүлэх зорилго бүхий 5,698.6 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийг Оюу толгой ХХК-аас хүлээн авч орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн.
- "Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай" Монгол Улсын Их Хурлын 2019 оны 92 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газраас байгуулагдсан ажлын хэсэг хөрөнгө оруулагч талтай хийх яриа, хэлэлцээрт хуулийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ авах зорилгоор гадны зөвлөх үйлчилгээг холбогдох шалгуурын дагуу авч, уг ажлын хүрээнд 1,666.6 сая төгрөгийн гадны зөвлөхийн зардал (үүнд оршин суугч бус этгээдээс суутгасан татвар, оршин суугч бус этгээдийн НӨАТ, зөвлөхийн төлбөр зэрэг багтсан)-ыг хүлээн зөвшөөрч бүртгэсэн бөгөөд тайлант оны эцсээр уг үйлчилгээнд 1,076.4 сая төгрөгийн төлбөр төлөхөөр тайлагнасан байна.
- Компанийн ТУЗ-ийн 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 252 дугаар "Энгийн хувьцаа гаргахыг зөвшөөрөх "2021 оны 1 дүгээр улирал" тогтоолын хүрээнд Оюу толгой

ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2021 оны 2 дугаар сарын 2-ны 4/21, 3 дугаар сарын 12-ны өдрийн 10/21, 3 дугаар сарын 15-ны 12/21 тоот тушаалуудыг үндэслэн компани санхүүгийн тайландаа Урт хугацаат хөрөнгө оруулалт, эзэмшигчийн өмчийн дүнгээ 58,135.4 сая төгрөгөөр буюу 5,813,541 ширхэг хувьцаагаар нэмэгдүүлсэн байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Эрдэнэс оюу толгой ХХК нь Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 348 дугаар тогтоол, “Эрдэнэс Монгол” ХХК (тухайн үеийн “Эрдэнэс МГЛ” ХХК)-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2011 оны 28 дугаар тогтоолуудыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг тус компанийн толгой компани болох Эрдэнэс Монгол ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл томилж байгаа нь Компанийн тухай тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь заалттай нийцэж байна.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшуулал, бусад хангамж зэрэг зардлыг шалгадагч байгууллага хариуцдаггүй бөгөөд түүний толгой компани бүрэн хариуцан ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд Эрдэнэс Оюу толгой ХХК нь тодорхой арга хэмжээ аваагүй болно.

Компани Оюу Толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах Монгол Улсын Их Хурлын 92 дугаар тогтоолын 7 дугаар заалт “Оюу толгой төслийн Монголын талын төлөөллийг хэрэгжүүлэгч байгууллагын санхүүгийн болон хүний нөөцийн чадавхыг олон улсын түвшинд хүргэж, бэхжүүлэх” мөн “Оюу Толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний тухай” 57 дугаар тогтоолын хүрээнд төсөлд холбогдох үйл ажиллагаа болон “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн чадавхыг сайжруулах хүрээнд тусгай арга хэмжээ авч компанийн 2021 оны бүтцийг 31 орон тоотой байсныг 2022 онд 39 орон тоо болгож өсгөсөн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан хувь хэмжээнд 2021 оны 6 дугаар сарын 11-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон.

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Эрдэнэс оюу толгой ХХК-ийн санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	45.4	5,349.0	5,303.6
Авлага	6.3	29.9	23.6
Урьдчилж төлсөн зардал		62.7	62.7
Үндсэн хөрөнгө	67.7	109.1	41.4
Биет бус хөрөнгө	0.3	11.1	10.8
Урт хугацаат хөрөнгө оруулалт	2,689,647.0	2,747,782.4	58,135.4
Хойшлогдсон татварын хөрөнгө		103.7	103.7
Нийт хөрөнгийн дүн	2,689,766.7	2,753,447.9	63,681.2
Богино хугацаат өглөг	3,503.7	6,226.9	2,723.2
Урт хугацаат өглөг	7,573.7	9,104.4	1,530.7
Эздийн өмч	2,678,689.3	2,738,116.6	59,427.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,689,766.7	2,753,447.9	63,681.2

Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэлд 0.3 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл байна.

Банк дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд байгаа 5,348.6 сая төгрөг байна. Энэ нь Оюу Толгой төслийн ажилд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэх ажлын хүрээнд Оюу толгой ХХК-аас 5,698.6 сая төгрөгийн урьдчилгааг хүлээн авсантай холбоотой.

Авлагын үлдэгдэлд НӨАТ-ын авлага 13.8 сая төгрөг, байгууллагаас авах авлага 16.0 сая төгрөг тус тус тусгагдсан байна. Энэ нь Моннис Пропертиис ХХК-д шилжүүлсэн оффисын түрээсийн барьцаа төлбөр байна.

Тайлант онд НӨАТ төлөгч байгууллага болж НӨАТ-ын авлага 13.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь авлагын өсөлтөд голлон нөлөөлжээ.

Тайлант оны эцэст Оюу толгой төслийн талаар бодит мэдээллийг олон нийтэд хүргэх, төслийн талаарх иргэдийн мэдлэг, хандлагыг тодорхойлох тоон судалгаа хийх, тайлан боловсруулах ажлын төлбөрт 88.5 сая төгрөгийг бүрэн шилжүүлж үйл ажиллагааны зардалд тусгасан байсныг ажил хүлээн авах гэрээний хугацаа болоогүй, ажлын үр дүн гараагүй зэргээс шалтгаалж 2021 онд ногдох хэсэг буюу 25.8 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд, 62.7 сая төгрөгийг урьдчилж төлсөн зардалд бүртгэж залруулсан.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Тайлант онд 85.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан нь Оюу Толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах УИХ-ын 92 дугаар тогтоолын 7 дугаар заалтын хүрээнд, Компанийн ТУЗ-ийн баталсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу худалдан авалтыг хийсэн байна.

Биет бус хөрөнгө 10.8 сая төгрөгөөр өссөн нь компани нь байгууллагын логог шинэчлэх, өөрчлөхтэй холбоотойгоор гарсан зардлыг капиталжуулсантай холбоотой байна.

Тайлант онд хараат компанид оруулсан урт хугацаат хөрөнгө оруулалт 58,135.0 сая төгрөг бүртгэгдсэн бөгөөд энэ нь Оюу толгой ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 4/21, 10/21, 12/21 тоот тушаалуудаар шинээр бүртгэсэнтэй холбоотой.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 6,226.9 сая төгрөгийн өр төлбөр байна. Урт хугацаат өр төлбөр дансанд 2012-2021 онуудад Эрдэнэс оюу толгой ХХК-ийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх шалтгаанаас үүссэн урт хугацаат хөрөнгө оруулалтын

хүүгийн төлбөр 4,552.0 сая төгрөг, орлогын татварын өглөг 596.2 сая төгрөг, зөвлөх үйлчилгээ үзүүлэгчдэд өгөх өглөг 1,076.4 сая төгрөг зэрэг байна. Энэхүү өсөлтийн гол шалтгаан нь УИХ-ын 2019 оны 92 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Засгийн газраас байгуулагдсан ажлын хэсэг хөрөнгө оруулагч талтай хийх яриа хэлэлцээрт хуулийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ авах зорилгоор гаднын зөвлөх үйлчилгээг холбогдох шалгуурын дагуу авч ажиллуулсантай холбоотой байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 9,104.4 сая төгрөгийн өр төлбөр байна. Энэ нь Эрдэнэс оюу толгой ХХК нь гүний уурхайн бүтээн байгуулалтын төсөлд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэх ажлыг санхүүжүүлэхтэй холбоотой Эрдэнэс монгол ХХК-аас хүлээн авсан санхүүжилтийн тооцооны үлдэгдэл байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйл ажиллагааны зардал, хүүгийн зардал гэж ангилсан байна. Зардал өмнөх онтой харьцуулахад үйл ажиллагааны зардал 2,509.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Оюу толгой ордын ашиглалтад Монгол улсын эрх ашгийг хангуулах тухай зөвлөх үйлчилгээ, судалгааны зардал гарснаас шалтгаалжээ.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Эрдэнэс оюу толгой ХХК нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрдэнэс оюу толгой ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2020 оны 04 дүгээр тушаалаар Эрдэнэс оюу толгой ХХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт зардлыг 2,118.0 сая төгрөгөөр тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 129.2 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Тайлант онд Эрдэнэс оюу толгой ХХК нь Оюу толгой ХХК-аас гүний уурхайн бүтээн байгуулалтын төсөлд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэхэд зориулж 5,698.6 сая төгрөгийн санхүүжилтийн, тендерийн худалдан авалт зохион байгуулахтай холбоотойгоор тендерийн бичиг баримт борлуулж 0.2 сая төгрөгийн, нийтдээ 5,698.8 сая төгрөгийн төлөвлөгдөөгүй орлогыг олсон байна.

Тайлант хугацааны нийт зардлын гүйцэтгэл 3,413.2 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,424.9 сая төгрөг буюу 171.7 хувиар илүү гүйцэтгэлтэй байгаа нь Улсын Их хурлын 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн "Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай" 92 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" 45 дугаар тогтоолын дагуу Оюу толгой ордын ашиглалтад Монгол улсын эрх ашгийг хангуулах тухай зөвлөх үйлчилгээ, судалгааны зардал гарсантай холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 27 нэр төрлийн компьютер, дагалдах хэрэгсэл худалдан авсан байна.

Компани тайлант онд 1,114.8 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь Эрдэнэс оюу толгой ХХК-аас гүний уурхайн бүтээн байгуулалтын төсөлд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлэх ажлыг санхүүжүүлэхтэй холбоотойгоор урьдчилгаа төлбөр хүлээн авснаас шалтгаалжээ.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Эрдэнэс оюу толгой ХХК нь Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих нийт 6,694.3 мянган төгрөгийн 70 мэдээллийг хугацаанд нь, ил тод мэдээлсэн байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Эрдэнэс оюу толгой ХХК нь тайлант онд ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу 1 удаагийн компьютер, дагалдах хэрэгслийн тендерийн худалдан авалтыг зохион байгуулж шилэн дансанд байршуулжээ. 39.4 сая төгрөгийн тавилга эд хогшил болон архивын программ хангамж худалдан авахаар төлөвлөсөн гүйцэтгэлийг хангаагүй байна. Тайлант оны худалдан авалтын төлөвлөгөөнд 129.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 85.3 сая төгрөгийн худалдан авалт хийжээ.

Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалган үзэхэд ажилчдын нийгмийн арга хэмжээний хүрээнд сагсан бөмбөгийн тэмцээн зохион байгуулахад 1.3 сая, бэлэг дурсгалын зүйл худалдан авахад 3.5 сая төгрөгийг зарцуулсан нь дээрх тогтоолын 1.3-т “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх”, 1.6-д “Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх” гэж заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, ТБОНӨХБАҮХАТХ-ийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн, Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын зарим заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 112.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 109.6 сая төгрөгийг залруулсан, 3.0 сая төгрөгийн алдаа, зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 31.2 сая төгрөгийн зөрчил илэрч, 31.1 сая төгрөгийн зөрчилд хүргүүлсэн 2 албан шаардлага, 0.1 сая төгрөгийн зөрчилд өгсөн 3 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	2	31.1	2	31.1	-	-	100.0
Зөвлөмж	3	0.1	3	0.1	-	-	100.0
Нийт дүн	5	31.2	5	31.2	-	-	100.0

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар мэргэжлийн үйлчилгээ, ажлын хэсгийн зардлыг тэр дундаа гадны зөвлөхийн зардлыг авч үзэх нь зүйтэй гэж шийдвэрлэв. Энэ зардал нь компанийн орлогын дэлгэрэнгүй тайлан дахь ерөнхий удирдлагын зардлын 60 гаруй хувийг эзэлж байгаатай холбоотой.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,283.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,276.0 сая төгрөгийн алдааг залруулж, 4.8 сая төгрөгийн алдаа зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 3.0 сая төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 3.0 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 19.5 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс 16.5 сая төгрөгөөс бага байгаа тул “Зөрчилгүй” дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 1,276.0 сая төгрөгийн 6 алдааг залрууллаа. Үүнд:

- Тайлант хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 7.3 сая төгрөгөөр илүү тооцоолж бичилт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “Үнэн зөв байх”, Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т “даатгуулагч болон ажил олгогч нь тогтоосон хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.
- Бэлэг дурсгалын зардалд 3.5 сая төгрөгийн, Компанийн лого, таних тэмдэг шинэчлэхэд 11.0 сая төгрөг тус тус зарцуулсныг үйл ажиллагааны зардлаар тайлагнасан. Энэ нь ААНОАТТХ-ийн 15.1-д “холбогдох шаардлагыг хангасан дараах зардлыг албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцож болно”, түүнчлэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.3 дахь заалт “жинхэнэ хэрэгжилтийн зарчим”, НББОУС2 Бараа материалын Зүйл 36 Тодруулга зэрэгт заасантай тус тус нийцээгүй байна.
- Нэг удаагийн буцалтгүй тусламжаар олгосон 6.3 сая төгрөг, хүүхдийн баяраар ажилчдын хүүхдүүдэд худалдан авсан бэлэгний 1.4 сая төгрөгийн гүйлгээг үндсэн үйл ажиллагааны зардалд тусгаж татвар ногдох орлогоос хасч тооцсон нь НББОУС1 Санхүүгийн тайлан

тодруулга Зүйл 102, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 15.1-тэй тус тус нийцэхгүй байна.

- Гэрээний хугацаа дуусаагүй, ажил хүлээж авсан акт үйлдээгүй 84.5 сая төгрөгийн гэрээний төлбөр болон 1.3 сая төгрөгийн тэмцээн уралдааны зардлыг буруу ангилан тайлант хугацааны үйл ажиллагааны зардлаар тусгасан. Энэ нь НББОУС1 Санхүүгийн тайлангийн толилуулгын Зүйл 103 Зардлын чиг үүргээр ангилан бүртгэх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.3 дахь заалт *“жинхэнэ хэрэгжилтийн зарчим”*, Сангийн сайдын 2014 оны 249 тушаалаар батлагдсан *“Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар”* зэрэгтэй нийцэхгүй байна.
- Толгой компаниас авсан урт хугацаат зээлийн тайлант хугацаанд ногдох 1,051.1 сая төгрөгийн зээлийн хүүний зардлыг татвар ногдох орлогоос бүрэн хасч орлогын албан татварыг тооцсон нь ААНОАТТХ-ийн 14.3-т *“хөрөнгө оруулагчаас албан татвар төлөгчид өмнө нь оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг гурав дахин нэмэгдүүлснээс илүү хэмжээний тухайн хөрөнгө оруулагчийн зээлд төлсөн хүүгийн төлбөрийг албан татвар ногдох орлогоос хасаж тооцохгүй...”* гэж заасантай нийцээгүй.
- Зардлын дансны гүйлгээг түүвэрлэн шалгахад 25.1 сая төгрөгийн цалингийн зардал, 10.0 сая төгрөгийн буцалтгүй тусламж, ковидтой холбоотой зардал, 1.3 сая төгрөгийн засварын зардал, 73.2 сая төгрөгийн бусад зардал, нийт 109.6 сая төгрөгийг буруу ангилан бүртгэсэн байна. Энэ нь НББОУС1 Санхүүгийн тайлангийн толилуулгын Зүйл 103-ын Зардлын чиг үүргээр ангилан бүртгэх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.3 дахь заалт *“жинхэнэ хэрэгжилтийн зарчим”*, Сангийн сайдын 2014 оны 249 тушаалаар батлагдсан *“Аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн заавар”* зэргийг зөрчиж байна.

8.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Компани нь толгой компани болох Эрдэнэс монгол ХХК-ийн боловсруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашиглаж байгаа бөгөөд энэ нь компанийн үйл ажиллагаанд тохирохгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.2-т *“аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах”* гэсэнтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Компанийн санхүү бүртгэлийн онцлогийг тусгасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, мөрдөн ажиллах;

2. Ашиглаж буй программ хангамжтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Ашиглаж буй Мэжик финанс санхүүгийн программаас бэлтгэдэг Гүйлгээ баланс буюу Ажлын хүснэгтийг Ерөнхий журналтай тулган шалгахад зөрүүтэй байна. Мөн үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл уг программд хөтлөгдөхгүй байгаа нь Сангийн сайдын 2018 оны 47 тоот тушаал, *“Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах*

шаардлага"-ын 1.10-т "санхүүгийн тайлангийн аудит хийхэд хялбар дөхөмтэй, мэдээллийн эх үүсвэрийг иж бүрнээр /анхан шатны баримтын мэдээлэл, дансанд бичилт хийсэн мэдээлэл/ тодорхой харуулдаг байх", 2.9 "мэдээллийн шивэлт давхардалгүй, боловсруулалтыг автоматаар хийдэг байх" гэсэнтэй тус тус нийцээгүй байна;

Өгсөн зөвлөмж:

Компанийн санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж буй программ хангамжийг өөрчлөх, шаардлага хангасан санхүүгийн программ хангамж ашиглан санхүү, бүртгэлээ хөтлөх;

3. Анхан шатны баримт бүрдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Ажлын хэсэгт зориулж худалдан авсан 3.1 сая төгрөгийн зарцуулалтын анхан шатны баримтын бүрдэл дутуу, зарцуулалтыг захирлын зөвшөөрөлгүйгээр хийсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "АШБ нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.5-д "АШБ-нд түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно..." гэж заасныг тус тус зөрчсөн.

Өгсөн зөвлөмж:

Бэлэн мөнгөний зарлага хийхдээ зөвшөөрөгдөх анхан шатны маягтуудыг бүрэн хэрэглэх, баримтын иж бүрэн байдлыг хангах, гүйлгээг дэмжих хүчин төгөлдөр баримтуудыг хавсаргах, дээд удирдлагын зөвшөөрөлгүйгээр гүйлгээг хийхгүй байх;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Үүнээс																
д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Эрдэнэс оюу толгой ХХК	АХГ-2022/64/НА-СТА-ТӨА	Компанийн ашиглаж буй бодлогын баримт бичиг нь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд тохирохгүй байна.	Компанийн санхүү онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж, мөрдөн ажиллах.	1	-									1	-
2	Эрдэнэс оюу толгой ХХК	АХГ-2022/64/НА-СТА-ТӨА	Ашигладаг санхүүгийн программаас бэлтгэдэг гүйлгээ балансыг ерөнхий журналтай тулгахад зөрүүтэй.	Программ хангамжийг шинэчилж хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийг программд нэвтрүүлэх.	1	-									1	-
3	Эрдэнэс оюу толгой ХХК	АХГ-2022/64/НА-СТА-ТӨА	Анхан шатны баримтын бүрдэл дутуу 3,051.9 мянган төгрөгийн гүйлгээг бүртгэсэн, уг зарцуулалтыг захирлын зөвшөөрөлгүйгээр хийсэн.	Анхан шатны баримтын их бүрэн байдлыг хангах, цаашид баримт бүрдүүлэлтийг ханган ажиллах.	1	3,051.9									1	3,051.9
4	Эрдэнэс оюу толгой ХХК	АХГ-2022/64/НА-СТА-ТӨА	Тайлант хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 7,315.9 мянган төгрөгөөр илүү тооцоолсон.	Илүү тооцсон НДШ-ийн зардлыг залруулж, мэргэжлийн үйлчилгээний зардал дансанд тусгах.	1	7315.9	1	7315.9								
5	Эрдэнэс оюу толгой ХХК	АХГ-2022/64/НА-СТА-ТӨА	Бэлэг дурсгалын зардалд 3,496.5 мянга, компанийн лого шинэчлэхэд зарцуулсан 14,496.5 мянган төгрөгийг үйл ажиллагааны зардлаар тайлагнасан.	Бэлэг дурсгалын зардлыг үйл ажиллагааны бус зардлаар, компанийн логотой холбоотой гарсан гүйлгээг биет бус хөрөнгөөр бүртгэх.	1	14,496.5	1	14,496.5								
6	Эрдэнэс оюу толгой ХХК	АХГ-2022/64/НА-СТА-ТӨА	Буцалтгүй тусламжийн 6,300.0 мянга, Хүүхдийн бэлэгний 1,372.7 мянган төгрөгийн гүйлгээг хасагдах зардлаар бүртгэсэн.	Буцалтгүй тусламж, хүүхдийн бэлгийн зардлыг татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлаар бүртгэх, орлогын татварыг залруулах.	1	7,672.7	1	7,672.7								

[illegible]



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 550/А0150053
АХГ-2022/64/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

Тайлант онд компани нь ажилчдын нийгмийн арга хэмжээний хүрээнд сагсан бөмбөгийн тэмцээн зохион байгуулахад 1,337,246.00 төгрөг, бэлэг дурсгалын зүйлсийг худалдан авахад 3,496,500.00 төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ нь Засгийн Газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.3-т "... зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх", 1.6-д "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх" гэж заасантай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн Газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах зөрчлийг арилган албан шаардлагын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрдэнэс Оюу Толгой ХХК-ийн Гүйцэтгэх захирал Н.Цэрэнбат, Ерөнхий нягтлан бодогч Г.Мөнхтөр нарт даалгав.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

НИЙСЛЭЛ-АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ

Д.ЭНХДАЛАЙ

Т.СУГАРСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-261230

Z:\Alban Shaardlaga\2022\03\5 Auditin 2 Gazar-233 Docx

0001081444